

Гэрээний дугаар: ..... Үйлчилгээний салбар: ..... Ажилтны нэр: .....

**ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Өргөдлийн маягтын төрөл:  Шинэ дугаар  Эзэмших эрх шилжих  Гэрээ шинэчлэх  
 Ургийн овог: ..... Эцэг/эхийн нэр: ..... Нэр: .....  
 Регистрийн дугаар: ..... Төрсөн огноо: .....  Эр  Эм  
 Албан ёсны хаяг:  
 Хот / Аймаг: ..... Дүүрэг / Сум: ..... Хороо / Баг: .....  
 Хороолол / Гудамж: ..... Байр: ..... Тоот: .....

Хэрэглэгч би дээрх хаягийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг Улсын Бүртгэлийн Ерөнхий хуулийн 15.5.1-д заасны дагуу гаргуулан авахыг Скайтел ХХК-д үүгээр зөвшөөрч байна.

**ХЭРЭГЛЭГЧИЙН НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ**

Одоо оршин суугаа хаяг:  
 Хот / Аймаг: ..... Дүүрэг / Сум: ..... Хороо / Баг: .....  
 Хороолол / Гудамж: ..... Байр: ..... Тоот: .....  
 Ажил эрхлэлт: ..... Ажлын газар: ..... Албан тушаал: .....  
 Гэр/гар утас: ..... Ажлын утас: ..... Факс: ..... И-мэйл хаяг: .....  
 Яаралтай болон шаардлагатай үед холбоо барих мэдээлэл:  
 Нэр: ..... Утас: ..... Таны хэн болох: .....  
 Нэр: ..... Утас: ..... Таны хэн болох: .....

Яаралтай болон шаардлагатай үед дээрх хүмүүст мэдээлэл хүргүүлэхийг зөвшөөрч байна.

**ШИНЭЭР АВЧ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Үндсэн багц:  10,000 багц  20,000 багц  40,000 багц  70,000 багц  100,000 багц  
 Таны сонгосон дугаар: \_\_\_\_\_ Хэрэглэгчийн нүүц үг:   
 Шинэ дугаарын төрөл:  Энгийн  Азын  Алтан  
 Бүртгэлийн хураамж: \_\_\_\_\_ ₮  
 Үндсэн барьцаа:  20,000₮  50,000₮  
 Нэмэлт барьцаа:  100,000₮\* /Олон улсын яриа, роуминг\*/  200,000₮\* /Олон улсын яриа, роуминг\*/  
 350,000₮\* /Олон улсын яриа, роуминг\*/

\*Үйлчилгээний нөхцөлийн дагуу яриа, мессеж, задгай дата хэрэглээ хязгаарлагдана.

\*\*Хэрэглээ хязгаарлагдахгүй

**ТӨЛБӨР ТӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ**

Төлбөрийн нэхэмжлэл хүлээн авах хэлбэр:  Мессеж  И-мэйл хаяг.....  Үйлчилгээний салбар  
 Төлбөр төлөх хэлбэр:  Бэлнээр  www.skytel.mn  Дансаар  ХХБ АТМ  Flycard  EZpay

Дугаар үүссэн огноо: \_\_\_\_\_

Үйлчилгээ авсан огноо: \_\_\_\_\_



# ДАРАА ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Энэхүү ДАРАА ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас: 2576376 тоот регистрийн дугаартай, 9011269026 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээтэй Монгол Улсын хуулийн этгээд болох SKАЙТЕЛ ХХК /цаашид "Үйлчилгээ үзүүлэгч" гэх/, Нэгөө талаас: Монгол Улсын Иргэн РД: \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_

/цаашид "Хэрэглэгч" гэх/ нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчид үүрэн телефон холбооны дараа төлбөрт үйлчилгээ /цаашид "Үйлчилгээ" гэх/-г үзүүлэх, Хэрэглэгч нь гэрээнд заасны дагуу зохих төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээний үйлчлэх хүрээнд гарах, орох дуудлага, үндсэн болон нэмэлт үйлчилгээ, гарах, орох мессежийн үйлчилгээ, хот доторх болон улс хоорондын үйлчилгээ мөн хөдөлгөөнт интернетиин үйлчилгээгээр үйлчлүүлэх бололцоогоор хангагдана.
- 1.3 Үйлчилгээний дугаар болон сим карт нь үйлчилгээ үзүүлэгчийн өмчлөлд байх бөгөөд гэрээний хүчин төгөлдөр хугацаанд тэдгээрийн зөвхөн эзэмшэх эрхийг Хэрэглэгчид олгоно.
- 1.4 Талууд онцгой нөхцөлд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний нөхцөл, заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд гэрээний нэмэлт өөрчлөлт хийх журмын дагуу шийдвэрлэнэ.
- 1.5 Энэхүү гэрээний өргөдлийн маягт болон Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийг энэхүү гэрээтэй хамт хэрэглэх ба эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээ нь Хэрэглэгч Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, гэрээний 2.3-д заасны дагуу болон Хэрэглэгчийн хүсэлтээр гэрээг цуцлахад хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 2.2 Талууд энэ гэрээний 2.3-д зааснаас бусад тохиолдолд гэрээг дангаар цуцлахыг хориглоно. Хэрэглэгч гэрээг цуцлах тухай саналыг үйлчилгээ үзүүлэгчид ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэж үйлчилгээг хаалгана.
- 2.3 Талууд дараах үндэслэлээр энэхүү гэрээг цуцалж болно. Үүнд:
  - 2.3.1 Гэрээнд заасан аль нэг үүргээ биелүүлээгүй бол;
  - 2.3.2 Хэрэглэгчийн эрх зүйн чадвар дууссаар болон;
  - 2.3.3 Хуульд заасан бусад үндэслэлээр.

## ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

### Хэрэглэгч нь дараах эрхтэй

- 3.1.1 Хэрэглэгч нь энэхүү гэрээгээр зөвхөн нэг дугаарыг эзэмшиж эрхтэй. Нэг Хэрэглэгч 5-аас ихгүй гэрээ байгуулна.
- 3.1.2 Хэрэглэгч аливаа үйлчилгээ хийлгэх болон дугаарын дэлгэрэнгүй мэдээлэл авахад зөвхөн өөрийн биеэр цахим үнэмлэхний хамт ирнэ. Хэрэглэгч өөрийн биеэр ирэх боломжгүйг нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг үндэслэн зөвхөн итгэмжлэлд заасан үйлчилгээг итгэмжлэгдсэн төлөөлөгчид үзүүлнэ.
- 3.1.3 Хэрэглэгч нь тодорхой шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн журамд заасан үйлчилгээг үүргийг өргөдлийн маягтад бөглөсөн баталгаат и-мэйл хаягаас хүсэлт илгээн авах эрхтэй.
- 3.1.4 Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчээс олгож буй үйлчилгээ, хөнгөлөлт, урамшуулал болон үнэ тарифын талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомж, Үйлчилгээ үзүүлэгчийн дүрэм, журам, үйлчилгээний нөхцөлийн хүрээнд авах эрхтэй.
- 3.1.5 Үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох баримт бичгийн дугаар, лиценз олгосон байгууллагын талаарх мэдээллийг шаардан үзэх.
- 3.1.6 Үйлчилгээний талаар санал, гомдол гаргах, талархал илэрхийлэх.
- 3.1.7 Үйлчилгээ үзүүлэгчийг гэрээгээр хүлээн үүргээ биелүүлэхийг шаардах.

### Хэрэглэгч нь дараах үүрэгтэй

- 3.2.1 Хэрэглэгч нь өргөдлийн маягтыг үнэн зөв бөглөх.
- 3.2.2 Хэрэглэгч нь өргөдлийн маягтын мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 хоногт багтаан Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх.
- 3.2.3 Үйлчилгээ үзүүлэгчээс олгож байгаа үйлчилгээг энэхүү гэрээ болон Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд заасан нөхцөлөөр ашиглах үүрэг хүлээнэ.
- 3.2.4 Хэрэглэгч гэрээний 3.1.3-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ гэрээний өргөдлийн маягтад бөглөсөн баталгаат и-мэйл хаягаас үйлчилгээ авах хүсэлт илгээхэд баталгаат гарын үсэгтэй өргөдлийг хавсарган, Үйлчилгээ үзүүлэгчийн журамд заасан нөхцөлийн дагуу үйлчилгээ авах үүрэг хүлээнэ.
- 3.2.5 Хэрэглэгч нь баталгаат и-мэйл хаяг болон гар утсан дахь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлаа хангах үүрэг хүлээнэ. Аюулгүй байдлаа хангаагүйгээс үүдэн гарах аливаа хохирол үр дагаврыг Хэрэглэгч бүрэн хариуцна.
- 3.2.6 Өмнөх сард ашигласан үйлчилгээний төлбөрөө дараа сарын 05-наас 20-ны дотор бүрэн төлөх.
- 3.2.7 Хэрэглэгч сим карт бүхий гар утсаас эсвэл сим картаа алдаж, үрэгдүүлсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээг хаах хүртэлх арга хэмжээг авах.
- 3.2.8 Хэрэглэгч нь гар утас, сим картаа гэрээнд заасны дагуу ашиглаж, зүй зохистой бүс хэрэглээ хийхгүй байх үүрэгтэй.
- 3.2.9 Гэрээгээр хүлээн үүргээ биелүүлэх.

## ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

### Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхтэй

- 4.1.1 Хэрэглээний хязгаарлалт бүхий хэрэглэгчийн хэрэглээ хязгаарт хүрсэн тохиолдолд гарах яриа, гарах мессеж, дата үйлчилгээг төлбөр төлөх хүртэл түр хаах.
- 4.1.2 Хэрэглэгч нь зүй зохистой бүс хэрэглээ хийсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч сануулаа хүргэж Хэрэглэгчийн үйлчилгээг хаах хүртэлх арга хэмжээг авах.
- 4.1.3 Үйлчилгээ үзүүлэгч нь зах зээлийн нөхцөл байдал, төрийн байгууллагын шийдвэрийн улмаас Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөл, үнэ тарифыг өөрчлөх эрхтэй ба энэ тохиолдолд Хэрэглэгчид ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мессеж, үйлчилгээний салбар болон www.skytel.mn вэб хуудсын аль нэгийг мэдэгдэх ба шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэнэ.
- 4.1.4 Хэрэглэгч нь ийнхүү мэдэгдсэнээс хойш өөрчлөгдсөн нөхцөлийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар ажлын 10 хоногийн дотор мэдэгдэгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн саналыг буюу нэмэлт өөрчлөлтгүй хүлээн зөвшөөрсөнд тооцох ба Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөл, үнэ тарифын өөрчлөлттэй танилцаагүй, мэдээгүй нь төлбөр төлөх үүрэг болон бусад үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 4.1.5 Үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд Хэрэглэгчид урьдчилан сануулалгүйгээр Хэрэглэгчийн гарах хэрэглээг барьцаанаас хамааруулан хязгаарлах эрхтэй. Үүнд:
  - 4.1.5.1 Гадаадын иргэн бол;
  - 4.1.5.2 Задгай хаягтай бол;
  - 4.1.5.3 Цахим үнэмлэхний хүчинтэй хугацаа дууссан бол;
  - 4.1.5.4 Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний салбаргүй сумын иргэн бол;
  - 4.1.5.5 Өмнө нь үүсгэсэн авлага төлөлгүй 6-наас дээш сар болсон Хэрэглэгчийг төлбөр төлснөөс хойш 6 сарын хугацаанд.
- 4.1.6 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үндэслэлээр Хэрэглэгчид урьдчилан сануулалгүйгээр үйлчилгээний эрхийг хаах эрхтэй. Үүнд:
  - 4.1.6.1 Төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй;
  - 4.1.6.2 Өргөдлийн маягтын мэдээллийг санаатайгаар худал мэдүүлсэн эсхүл 3.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол;
  - 4.1.6.3 Хэрэглэгч гэрээний хаяг дээрээ оршин суудаггүй болох нь тогтоогдсон бол;
  - 4.1.6.4 Үйлчилгээ үзүүлэгчийн бусад үйлчилгээнд төлбөрийн маргаантай бол.
- 4.1.7 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй нөхцөлд өр авлага барагдуулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, гуравдагч этгээдэд хэрэглэгчийн талаарх болон гэрээний тухай мэдээллийг өгөх, төлбөрийг шаардах эрхийг хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх.
- 4.1.8 Хэрэглэгч дахин шинэ дугаар худалдан авах хүсэлт гаргасан тохиолдолд өмнө байгуулсан гэрээтэй холбоотой ямар нэгэн төлбөр тооцоотой асуудал үүссэн бол дахин гэрээ байгуулахаас татгалзах.
- 4.1.9 Үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
  - 4.1.9.1 Тухайн дугаарыг худалдан аваад хэрэглээ хийгээгүй, ашиглаагүй, дугаар хадгалах үйлчилгээнд бүртгүүлээгүй буюу тухайн дугаар идэвхгүй төлөвт шилжсэнээс хойш 6 дахь сард;
  - 4.1.9.2 Төлбөрийн үлдэгдэлтэй дугаарыг идэвхгүй төлөвт шилжсэнээс хойш 6 дахь сард;

4.1.9.3 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр дугаараа хадгалуулсан тохиолдолд дугаар хадгалалтын хугацаа дуусаж, идэвхгүй төлөвт шилжсэнээс хойш 6 дахь сард.

### Багийн хэрэглээний эрх

- 4.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчид үйлчилгээг өөрийн техникийн боломж болон хүчин чадлын хүрээнд чанарын өндөр түвшинд үзүүлэх.
- 4.2.2 Хэрэглэгчийн хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг гэрээ байгуулсан тухайн дугаарын эзэмшигчид цахим үнэмлэхийг үндэслэн, дугаар эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг үндэслэн олгох.
- 4.2.3 Хэрэглэгчийн сар бүрийн хэрэглээний төлбөрийн нэхэмжлэхийг гэрээнд заасан и-мэйл хаяг, мессежээр хэрэглэгчид мэдэгдэх.
- 4.2.4 Гэрээгээр хүлээн үүргээ биелүүлэх.

## ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1 Хэрэглэгч нь гар утсаа алдаж, үрэгдүүлсэнтэй холбоотойгоор үйлчилгээг түр хаалгах хүсэлтээ өгөх хүртэлх гэрээнд дээрх төлбөр тооцоогоо өөрөө бүрэн хариуцна. Хэрэглэгч нь дугаар ашиглах эрхээ Үйлчилгээ үзүүлэгчид албан ёсоор хандан гэрээний үндсэн дээр шилжүүлэхээс бусад байдлаар дур мэдэн гуравдагч этгээдэд шилжүүлсэн бол түүнээс үүдэн гарах хохирлыг бие даан бүрэн хариуцна.
- 5.2 Хэрэглэгч дугаараа эсхүл гар утсаа гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй байдлаар дамжуулсан, ашиглуулсан, аль нэг програмыг буруу ажиллуулсан эсвэл энэхүү гэрээний 3.2.8-д заасан үүргээ зөрчсөнөөс үүсэн гарах аливаа үр дагавар, хохирол, зардлыг Хэрэглэгч бүрэн хариуцна.
- 5.4 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, төлбөрийн үлдэгдэлтэй бөгөөд өргөдлийн маягтад заасан хангтаа байхгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн үйлчилгээний төлбөр төлөх үүргийн талаар болон өр авлага барагдуулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, Хэрэглэгчийг эрэн сурвалжлах зорилгоор гуравдагч этгээдэд Хэрэглэгчийн талаарх болон гэрээний тухай мэдээллийг өгөх, шалгуулах, төлбөр төлөхийг шаардах эрхийг Хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр шийдвэрлэнэ.
- 5.5 Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний өргөдлийн маягтад өгөгдсөн Хэрэглэгчийн мэдээлэл болон үйлчилгээний гэрээ, хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг өөрийн нууцад хамааруулан хадгалах бөгөөд дараах тохиолдлуудад гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхтэй. Үүнд:
  - 5.5.1 Хэрэглэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн авлагыг барагдуулах зорилгоор;
  - 5.5.2 Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шаардсанаар.
- 5.6 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн нууцад хамаарах мэдээллийг хууль бусаар олж авах аливаа үйлдэл хийсэн, тийнхүү олж авсан мэдээллийг хувийн болон бусад зорилгоор ашигласан, хэрэглэсэн, бусдад задруулсан бол энэхүү үйлдлийн улмаас учирсан эсхүл учирч болох аливаа хохирлыг бүрэн хариуцахын зэргэцээ хуульд заасан бусад хариуцлага хүлээнэ.

## ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО

- 6.1 Үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээний төлбөрийг сар бүрийн 01-нээс 31-ний өдөрөө тасалбар болгон дараа сарын 05-ны дотор Хэрэглэгчээс нэхэмжилнэ. Хэрэглэгч хэрэглээ хязгаарлах үйлчилгээ идэвхжүүлсэн тохиолдолд задгай яриа, мессеж, дата хэрэглээ нь хэрэглээ хязгаарлах түвшинд хүрсэн бол 05-ны өдрөөс үл хамааран хаагдана.
- 6.2 Төлбөрийн нэхэмжлэл нь тухайн сарын суурь хураамж, сарын хэрэглээний дүнгээс зохих хөнгөлөлтийг хасаж тооцсоны дараах дүн, төлбөрийн үлдэгдэл, НӨАТ зэргээс бүрдэнэ.
- 6.3 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчийн заасан дансанд, үйлчилгээний салбарт бэлнээр, мобайл банк, www.skytel.mn болон бусад боломжтой сувгаар төлнө.
- 6.4 Хэрэглэгч нь 6.1-д заасан төлбөрийг нэхэмжилсэн сарын 20-ны дотор үлдэгдэлгүй, бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- 6.5 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрөө цаг тухайд нь төлөөгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг бүрэн хааснаас хойш Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийн дагуу барьцаа төлбөрөөс Хэрэглэгчийн үйлчилгээний төлбөрийг суутгах эрхтэй.
- 6.6 Төлбөрийн улмаас хаалттай дугаарт төлбөрөө бүрэн төлөгдөх хүртэл хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт олгохоос бусад үйлчилгээг үзүүлэхгүй.
- 6.7 Хэрэглэгч гэрээг буюу дугаарыг цуцлах өдрийг хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний төлбөрийг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 6.8 Гэрээний 6.1-д заасан хугацаанд төлбөр нэхэмжлээгүй эсвэл 4.1.6.1-д заасны дагуу үйлчилгээ хаагаагүй нь төлбөр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.9 Үйлчилгээ үзүүлэгч төлөгдөөгүй төлбөрийг барагдуулахтай холбогдон гарсан нэмэлт зардлыг Хэрэглэгчээс нэхэмжлэх эрхтэй.
- 6.10 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь хугацаа хэтэрсэн хоног тутамд нэхэмжилсэн төлбөрийн үнийн дүнгээс 0,3% алданги тооцож нэхэмжлэх эрхтэй.
- 6.11 Хэрэглэгчийн барьцаа төлбөр нь нийт төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй бол Үйлчилгээ үзүүлэгч үлдэгдэл төлбөрийг нэхэмжлэх эрхтэй.
- 6.12 Барьцаа төлбөр байгуулаагүй нь Хэрэглэгч хэрэглээний төлбөрийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.

## ДОЛОО. ДАВАГДАШҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар тухайлбал гал түймэр, үер, хүр тунадас болон шороон шуурга, газар хөдлөлт, яанга цахилгаан, галт уулын болон бусад тэсрэлт, дэлбэрэлт, цаг агаарын хэт халалт ба хүйтрэлт эсхүл төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цэврийн дэглэм, гоц халдварт өвчин, ажил хаялт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн, дайн /зарлагдсан болон зарлагдаагүй/, террорист халдлага, түши, эрчим хүчний хязгаарлалт, сүлжээний эгч ачаалал, доголдол, тасалдал зэрэг гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй нөхцөл байдлын улмаас Талууд гэрээгээр хүлээн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас үүдсэн нөхцөл байдал 30 хоногос дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Талууд гэрээг цуцлах талаар саналаа албан ёсоор бичгээр гаргах эрхтэй.

## НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөж замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэх чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийг заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.2 Хэрэглэгч гэрээг мөнгөн хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Хэрэглэгч өргөдлийн маягт түүнд агуулагдсан мэдээллийг үнэн зөв өгч, Талууд энэхүү гэрээний нөхцөлд заасан бүхий л заалтууд болон Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаага нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

### ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛЖ:

Үйлчилгээний салбар, утас: .....

Үйлчилгээний ажилтан: .....

### ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

..... овогтой .....

Гарын үсэг: .....

Гэрээ байгуулсан огноо: 20 ..... оны ..... сарын ..... өдөр

- НЭГ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ**
- 1.1 Энэхүү Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд дараах нэр, томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- 1.1.1 "Бүртгэлийн хураамж" гэж шинэ хэрэглэгчийн дугаарын нэг удаагийн, эргэн төлөгдөхгүй төлбөрийг;
  - 1.1.2 "Барьцаа төлбөр" гэж Хэрэглэгч хэрэглээний төлбөр төлөх үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хэрэглэгчээс урьдчилан төвлөрүүлсэн хөрөнгийг;
  - 1.1.3 "Сарын суурь хураамж" гэж Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээг ашигласнаар сар бүр тогтмол төлөх төлбөрийг;
  - 1.1.4 "Багцын хэрэглээний эрх" гэж Хэрэглэгчийн ашиглаж буй багцын сарын суурь хураамжид багтаж буй (яриа, мессеж, дата эрх) үйлчилгээний эрхийг;
  - 1.1.5 "Нэмэлт үйлчилгээ" гэж хэрэглэгчийн ашиглаж байгаа яриа, мессеж, дата хэрэглээнээс бусад нэмэлтээр үзүүлж буй үйлчилгээг;
  - 1.1.6 "Үйлчилгээний төлбөр" гэж Хэрэглэгчийн дугаарт бодогдсон, тухайн сарын хэрэглээний төлбөр, сарын суурь хураамж, бусад холбогдох төлбөр, хөнгөлөлт болон НӨАТ зэргийн нийлбэр дүнг;
  - 1.1.7 "Үйлчилгээ хооронд шилжих" гэж Хэрэглэгч дугаар солилгүйгээр ашиглаж буй багцаа өөрчлөхийг;
  - 1.1.8 "Дугаар хадгалах үйлчилгээ" гэж Хэрэглэгч дугаараа ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбарт хандаж 12 сар хүртэлх хугацаанд бүрэн хаалгаж, хадгалуулах үйлчилгээг;
  - 1.1.9 "Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарыг түр хаах" гэж Хэрэглэгч дугаараа ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбарт хандаж 3 сар хүртэлх хугацаанд бүрэн хаалгаж үйлчилгээг;
  - 1.1.10 "Эзэмших эрх шилжүүлэх" гэж Хэрэглэгч өөрийн нэр дээр эзэмшиж буй дугаарыг үйлчилгээний нэр дээр шилжүүлэх үйлчилгээг;
  - 1.1.11 "Дугаар солих" гэж Хэрэглэгчийн эзэмшиж буй дугаарын сүүлийн 4 оронг солих үйлчилгээг;
  - 1.1.12 "Сим карт сэргээх" гэж Хэрэглэгч шинээр сим карт худалдан авахыг;
  - 1.1.13 "Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт" гэж Хэрэглэгчийн гарах яриа, мессеж хэрэглээ хийсэн дугаарын жагсаалт болон бодогдсон төлбөрийн мэдээллийг, эсвэл Дата үйлчилгээний хэрэглээний жагсаалт болон бодогдсон төлбөрийн мэдээллийг;
  - 1.1.14 "Үйлчилгээ зогсоох" гэж орох гарах яриа, мессеж, дата үйлчилгээний эрхийг зогсоох;
  - 1.1.15 "Биллинг цикл" гэж сарын эхний өдрөөс сарын сүүлийн өдөр дуусгал хугацааг;
  - 1.1.16 "Зүй зохистой бус хэрэглээ" гэж бусад хэрэглэгчийг залгаах, дарамтлах, гутан доромжлох, өөр бусад байдлаар бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, сүлжээний хэвийн үйл ажиллагааг саатуулах, нэг дор их хэмжээний мессеж илгээх, зар сурталчилгааны шинжтэй болон хуулар хориглоосон өгөгдөл дамжуулах; бусад хүндрэл учруулах зэргээр үйлчилгээний нөхцөлд тусгаагүй хэрэглээг;
  - 1.1.17 "Олон улсын роуминг үйлчилгээ" гэж Хэрэглэгч гадаад улсад зорчихдоо өөрийн дугаараа ашиглан гадаадын операторууд /зөвхөн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан гадаадын операторууд/-ын сүлжээг ашиглах үйлчилгээг ойлгоно.

**ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ**

- Шинэ хэрэглэгч болох**
- 2.1 1.1 Хэрэглэгч дараах бичиг баримтыг бүрдүүлэн өөрийн биеэр үйлчилгээний салбарт хандана. Үүнд:
    - Цахим үнэмлэх, цахим үнэмлэхийн лавлагаа /хүчинтэй хугацаа дуусаагүй/
    - Хэрэглэгчийн сонгосон дугаарын бүртгэлийн хураамж, багцын барьцаа төлбөр
  - 2.2 **Бүртгэлийн хураамж**
  - 2.3 2.1 Хэрэглэгчийн сонгосон дугаараас хамаарч бүртгэлийн хураамж харилцан адилгүй байна.
  - 2.3 **Сарын суурь хураамж**
  - 2.3.1 Хэрэглэгч дараах нөхцөлүүдэд сарын суурь хураамж төлөхгүй. Үүнд:
    - Хэрэглэгч тухайн сарын турш орох, гарах яриа, мессеж болон дата хэрэглээ хийгээгүй, мөн нэмэлт үйлчилгээ идэвхжүүлээгүй тохиолдолд;
    - Хэрэглэгч дугаар хадгалуулах үйлчилгээг авсан тохиолдолд;
    - Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарыг тухайн сарын эхний өдрөөс түр хаасан тохиолдолд.
  - 2.3.2 Сарын дундуур шинэ хэрэглэгч болсон тохиолдолд зөвхөн тухайн сарын суурь хураамжийг дараах нөхцөлийн дагуу тооцно.

Шинэ хэрэглэгч болсон өдөр	Сарын суурь хураамж тооцох хувь
1-10-ны өдрүүдэд	100%
11-20-ны өдрүүдэд	50%
21-31-ний өдрүүдэд	30%

- 2.3.3 Хэрэглэгч сарын турш хэрэглээ хийгээгүй, дугаар хадгалах үйлчилгээнд бүртгүүлээгүй тохиолдолд дугаар хадгалах үйлчилгээний төлбөр 5000F-ийг хэрэглээ хийгээгүй сар бүр нэхэмжлэх дээр тооцогдоно.
- 2.4 **Багцын хэрэглээний эрх**
- 2.4.1 Багцын дата эрхийг Скайтелийн сүлжээнд ашиглах боломжтой ба дата эрх дууссан тохиолдолд заагдах тарифаар тооцогдоно.
- 2.4.2 Багцын ярианы эрхийг Скайтелийн сүлжээнд болон харилцан холболт бүхий дотоодын операторуудын сүлжээнд ашиглах боломжтой;
- 2.4.3 Тусгай дугаарын яриа, олон улсын төлбөр болон роумингийн ярианы хэрэглээ багцын ярианы эрхэд хамаарахгүй.
- 2.4.4 Багцын хэрэглээний эрхийг ашиглах нөхцөл:
  - Тухайн сардаа ашиглаж дуусаагүй ярианы эрхийн хэрэглээ дараагийн 1 сард шилжинэ.
  - Багц шилжсэн тохиолдолд өмнөх сардаа ашиглаж дуусаагүй ярианы эрхийн хэрэглээ дараагийн сард шилжихгүй.
  - Тухайн сардаа ашиглаж дуусаагүй дата эрхийн хэрэглээ дараагийн сард шилжихгүй.
  - Хэрэглээний эрхийг зүй зохисгүй ашиглахыг хориглоно.
- 2.5 **Үйлчилгээний хугацаа**
- 2.5.1 Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг байгуулсан өдрөөс эхлэн үйлчилгээний хугацааг тооцно.
- 2.5.2 Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг цуцалсан өдрөөр үйлчилгээний хугацаа дуусгавар болно.
- 2.6 **Сим карт сэргээх**
- 2.6.1 Хэрэглэгч үйлчилгээний салбарт хандан 3000 төгрөг төлж сим картаа сэргээлгэнэ;
- 2.6.2 Хэрэглэгч анх удаа 3G сим карт авч байгаа тохиолдолд сим картыг хэрэглэгчид үнэгүй олгоно;
- 2.6.3 Бусад тохиолдолд 2.6.1 дэх заалтад заасан төлбөрийг төлнө.

**ГУРАВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ**

- Багц хооронд шилжих**
- 3.1.1 Багц хооронд шилжих тохиолдолд дараа сарын 01-ний өдрөөс шилжих бөгөөд хэрэглэгч үйлчилгээ үзүүлэгчтэй Дараа төлбөрт үйлчилгээний гэрээ байгуулна.
  - 3.1.2 Сонгосон багцын барьцаа төлбөр их бол зөрүүг нэмж байршуулна.
  - 3.1.3 Хэрэглэгч багц ахиулах тохиолдолд нэмэлт төлбөр төлөхгүй ба багц бууруулах тохиолдолд 5000F-ийн төлбөрийг төлнө.
  - 3.1.4 Багц хооронд шилжсэн хэрэглэгчийн нэмэлт үйлчилгээний эрхийг хэвээр шилжүүлэх ба нэмэлт үйлчилгээний эрх дууссан тохиолдолд хэрэглэгч тухайн нэмэлт үйлчилгээг цуцлах хүсэлт гаргаагүй бол үргэлжлүүлэн ашиглана.
  - 3.2 **Хэрэглэгчийн хүсэлтээр дугаар хаах, нээх**
  - 3.2.1 Хэрэглэгч дугаараа хаалгах тохиолдолд үйлчилгээний салбарт өөрийн биеэр цахим үнэмлэхийн хамт ирж дугаарыг тухайн өдрөөс эхлэн хаалгах ба өмнөх төлбөр тооцоог бүрэн төлсөн тохиолдолд үйлчилгээг үнэгүй хаана.
  - 3.2.2 Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарыг 3 /биллинг цикл/ хүртэлх сарын хугацаатай хаана.
  - 3.2.3 Хэрэглэгч дугаараа нээлгэх хүсэлт гаргасан тохиолдолд үйлчилгээний салбарт өөрийн биеэр цахим үнэмлэхийн хамт ирж дугаарыг тухайн өдрөөс эхлэн нээлгэх ба үйлчилгээний эрхийг хэрэглэгчийн цахим үнэмлэхийг үндэслэн, өмнөх төлбөр тооцоог бүрэн төлсөн тохиолдолд үйлчилгээг нээнэ.
  - 3.2.4 Сарын дундуур үйлчилгээ нээлгэх болон хаалгах хүсэлт гаргаж байгаа тохиолдолд үйлчилгээний суурь хураамж бүтэнээр бодогдож үйлчилгээний эрхийг бүтэн олгоно.
  - 3.3 **Дугаар хадгалах үйлчилгээ**
  - 3.3.1 Хэрэглэгч нийт төлбөрийн үлдэгдлээ барагдуулсны дараа дугаар хадгалуулах үйлчилгээнд хамрагдах боломжтой.
  - 3.3.2 Үйлчилгээг гурав болон түүнээс дээш сар ашигласан хэрэглэгч дугаар хадгалах үйлчилгээнд хамрагдах боломжтой.
  - 3.3.3 Хэрэглэгч үйлчилгээний салбарт хандаж дугаар хадгалах үйлчилгээнд бүртгүүлсэн тохиолдолд эхний 3 /биллинг цикл/ сар дугаарыг төлбөргүй хадгална.
  - 3.3.4 Хэрэв 3 сараас дээш хугацаанд дугаараа ашиглахгүй тохиолдолд 4 дэх сараас эхлэн дугаар хадгалуулах үйлчилгээний төлбөр 5000F-ийг сар бүр төлж 12 сарын хугацаагаар дугаараа хадгалуулах боломжтой.

- 3.3.5 Хэрэглэгч сарын дундуур дугаар хадгалуулах хүсэлт гаргасан бол үйлчилгээний сарын суурь хураамжийг бүтэн нэхэмжлэн суурь хураамжид дагалдах эрхийг бүтэн олгоно.
- Үйлчилгээ хооронд шилжих**
- 3.4.1 Хэрэглэгч урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжих боломжтой ба энэ тохиолдолд Дараа төлбөрт үйлчилгээний гэрээ байгуулна.
- 3.4.2 Хэрэглэгч дараа төлбөрт үйлчилгээнээс илгээх урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих тохиолдолд тухайн үйлчилгээг 3 сараас баггүй хугацаанд тасралтгүй ашигласан, үйлчилгээний нийт төлбөрийг төлсөн байх шаардлагатай.
- 3.4.3 Хэрэглэгч үйлчилгээ хооронд шилжих тохиолдолд өмнөх үйлчилгээний ашигласан хугацаа, дансан дахь нэгж болон илүү төлөлийн дүн өөрчлөгдөхгүй.

**ДӨРӨВ. ДУГААР СОЛИХ**

- 4.1 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд үйлчилгээний салбарт өөрийн биеэр цахим үнэмлэхийн урьдчилсан хамт ирж Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг шинээр байгуулж, Дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгчийн үйлчилгээг хүсэн маат бөглөнө.
- 4.2 Дугаар солих тохиолдолд 20000F-ийн үйлчилгээний төлбөртэй бөгөөд хэрэглэгчийн дугаарын багцад дагалдах эрх болон нэмэлт үйлчилгээний эрхийг хэвээр шилжинэ.

**ТАВ. ГЭРЭЭ ШИЛЖҮҮЛЭХ**

- 5.1 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд эзэмших эрх шилжүүлэгч болон эзэмших эрх хүлээн авагч тус тус өөрийн биеэр цахим үнэмлэхийн хамт үйлчилгээний салбарт ирнэ.
- 5.2 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд сар бүрийн 06-ны өдрөөс эхлэн шилжүүлэх бөгөөд нийт төлбөрийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна.
- 5.3 Эзэмших эрх шилжүүлсэн тохиолдолд хүлээн авсан хэрэглэгчтэй Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг байгуулна.
- 5.4 Хүндэтгэх шалтгаанаар эзэмших эрх шилжүүлэх. Үүнд:
  - 5.4.1 Дугаар эзэмшигч нас барсан тохиолдолд:
    - Эзэмшигчийн нас барсны гэрчилгээг;
    - Эзэмшигчийн гэр бүлийн гишүүн /гэр бүлийн гишүүн гэдгийг эзэмшигчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, насанд хүрсэн төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүүг ойлгоно./ болохыг нотолсон лавлагааг;
    - Дугаарын эрх шилжүүлэн авагч нь цахим үнэмлэхээ авчирна.
  - 5.4.2 Дугаар эзэмшигч гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа тохиолдолд:
    - Тухайн улсад /гадаадад/ оршин сууж буйг нотолсон баримт бичиг;
    - Гадаад паспортын хуулбар, визийн хамт;
    - Дугаар эзэмшигч болон хүлээн авагчийн цахим үнэмлэх;
    - Дугаарын эзэмших эрхээ шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай баталгааг гарын үсэгтэй өргөдөл, хүсэлт.

**ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО**

- 6.1 **Ярианы минутын алхам тооцоолол**
- 6.1.1 Монгол улс дотор яриаг 1 (нэг) минутын алхмаар тооцох бөгөөд нэг минут хүрээгүй яриаг нэг бүхэл минутаар тооцно. Хэрэглэгчийн хэрэглэж буй үйлчилгээний багцаас хамаарч нэг минутын тариф харилцан адилгүй байна.
- 6.1.2 Олон улсын яриаг 6 (зургаан) секундын алхамтай бүрэн бус минутаар тооцох бөгөөд холбогдож буй тухайн улсаас хамаарч нэг минутын ярианы тариф харилцан адилгүй байна.

**Хэрэглээний мэдээлэл**

- 6.2.1 Хэрэглэгч сар бүрийн 06-ны өдрөөс хойш 1510 тусгай дугаарт В үсгийг мессежээр илгээж хэрэглээний төлбөрийг, U үсгийг мессежээр илгээж хэрэглээний мэдээллийг, D үсгийг илгээж дата хэрэглээний талаарх мэдээллийг тус тус мессеж хэлбэрээр авах боломжтой.

**Төлбөр төлөх боломж**

- 6.3.1 Хэрэглэгч ашигласан хэрэглээний төлбөрийг сар бүрийн 20-ны дотор доорх сүвгүүдээс сонгон төлөх боломжтой. Үүнд:
  - 6.3.2 Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний салбарт хандаж төлөх;
  - 6.3.3 Скайтелийн нэгжийн карт ашиглан төлбөрөө төлөх;
  - 6.3.4 www.skytel.mn вэб сайт, Skytel төлбөр банкны аппликэйшнаар төлөх;
  - 6.3.5 Скайдиллерт хандаж төлөх;
  - 6.3.6 Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны АТМ-ээр;
  - 6.3.7 Банкны автомат данс ашиглан төлөх;

**Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт авах**

- 6.4.1 Хэрэглэгч сүүлийн 3 сарын хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт авах боломжтой;
- 6.4.2 Хэрэглэгчийн хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт А4-ийн 1-5 хүртэлх нүүр бол 0 төгрөг, 6-15 хүртэлх нүүр бол 2000 төгрөг, 16-наас дээш нүүр болсон тохиолдолд 5000 төгрөг төлнө;

БАНК	Төгрөгийн данс
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	499 120 987
ХААН БАНК	503 801 9105
ГОЛОМТ БАНК	110 204 6354
ТӨРИЙН БАНК	106 000 002 843
ХАС БАНК	500 167 8218
УЛААНБААТАР ХОТЫН БАНК	261 700 0044

**ДОЛОО. ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОГСООХ, ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮСЭЛТЭЭР ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**

- 7.1 Тухайн сарын хэрэглээний төлбөрийг дараа сарын 20-ний дотор төлөөгүй тохиолдолд сарын сүүлийн өдөр хүртэл гарах үйлчилгээний эрхийг зогсоож, орох үйлчилгээний эрхийг үлдэх бөгөөд сарын сүүлийн өдөр орох, гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл зогсооно.
- 7.2 Багцаас хэтрэн яриа, мессеж, дата хэрэглээний төлбөр хэрэглээний хязгаарлалтын дүнд хүрсэн тохиолдолд 7.1-т заасан хугацаанаас үл хамааран гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл зогсоох ба орох үйлчилгээний эрх нээлттэй байна.
- 7.3 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцлах тохиолдолд үйлчилгээний төвд өөрийн биеэр цахим үнэмлэхийн хамт ирэх бөгөөд дараах төлбөрүүдийг төлж барагдуулсан байна. Үүнд:
  - Гэрээг цуцлах хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний нийт төлбөр;
  - Бусад төлбөрүүд.
- 7.4 Хэрэглэгч гэрээ цуцлах хүсэлтээ албан ёсоор мэдэгдээгүй болон дугаар хадгалуулах үйлчилгээ аваагүй тохиолдолд тухайн дугаарыг төлбөрийн улмаас идэвхгүй төлөвт шилжсэнээс хойш 181 дэх хоногт барьцаа төлбөрөөс хэрэглээний нийт төлбөрийг суутгах ба барьцаа төлбөрөөс хэтэрсэн үлдэгдэл төлбөрийг хэрэглэгч бүрэн хариуцан барагдуулна.

**НАЙМ. ОЛОН УЛСЫН РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 8.1 Хэрэглэгч олон улсын роуминг үйлчилгээг авсан тохиолдолд дараах үйлчилгээнүүдийг ашиглах боломжтой. Үүнд:
  - Өөрийн улс руу болон гадаад улс руу дуудлага хийх, хүлээн авах;
  - Мессеж илгээх, хүлээн авах;
  - Дата үйлчилгээг ашиглан интернетэд холбогдох.
- 8.2 Олон улсын роуминг үйлчилгээг Олон улсын цогц роуминг үйлчилгээний гэрээнд заасны дагуу авна.
- 8.3 Хэрэглэгч олон улсын роуминг үйлчилгээг ашиглахдаа дараах зүйлийг анхаарна.
  - Хэрэглэгч зорчих улсынхаа үүрэн операторын роуминг үйлчилгээний тарифтай урьдчилан танилцах;
  - Олон улсын роуминг үйлчилгээний төлбөр өндөр гарах магадлалтай тул хэрэглэгч хэрэглээгээ тогтмол хянах.

**ЕС. БУСАД**

- 9.1 Энэхүү дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд шүүд заагаагүй, тусгаагүй бусад үйлчилгээний нөхцөлийг тухайн үед Скайтел ХХК-ийн Хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдах ба Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд Скайтел ХХК дангаараа өөрчлөлт оруулах эрхтэй.

## Үйлчилгээний мэдээлэл

Мэдээллийн агуулга	www.skytel.mn
Дараа төлбөрт үйлчилгээний танилцуулга	www.skytel.mn > Бүтээгдэхүүн үйлчилгээ > Дараа төлбөрт үйлчилгээ
Шинэ хэрэглэгч болох нөхцөл	www.skytel.mn > Бүтээгдэхүүн үйлчилгээ > Дараа төлбөрт үйлчилгээ> Шинэ хэрэглэгч болох
Бүртгэлийн хураамж	www.skytel.mn > Бүтээгдэхүүн үйлчилгээ > Дараа төлбөрт үйлчилгээ> Дугаарын үнэлгээ
Барьцаа төлбөр	www.skytel.mn > Бүтээгдэхүүн үйлчилгээ > Дараа төлбөрт үйлчилгээ> Барьцаа төлбөр
Дата үйлчилгээний танилцуулга	www.skytel.mn > Бүтээгдэхүүн үйлчилгээ > Дата үйлчилгээ
Нэмэлт үйлчилгээний танилцуулга	www.skytel.mn > Бүтээгдэхүүн үйлчилгээ > Нэмэлт үйлчилгээ
Олон улсын роуминг үйлчилгээний танилцуулга	www.skytel.mn > Бүтээгдэхүүн үйлчилгээ > Олон улсын үйлчилгээ > Роуминг үйлчилгээ
Олон улсын ярианы 002 гарцын танилцуулга	www.skytel.mn > Бүтээгдэхүүн үйлчилгээ > Олон улсын үйлчилгээ > ОУ ярианы гарц 002
Үйлчилгээний салбаруудын хаяг, цагийн хуваарь	www.skytel.mn > Танд тусалъя> Үйлчилгээний салбар

## Дугаарын ангилал

Дугаарын ангилал	Дугаарлалт
Алтан	9AAA-AAAA, 9BAA-AAAA, 9xBA-AAAA, 9xBB-AAAA, 9xAB-9xAB, 9xAB-ABAB
Азын	9xxx-AABB, 9xxx- ABAB, 9xxx-ABBA
Энгийн	Бусад дугаарлалтууд

### Үйлчилгээтэй холбоотой хэрэгцээт мэдээлэл авах

Үйлчилгээний нөхцөл болон үйлчилгээтэй холбоотой бусад шаардлагатай мэдээллийг хамгийн хурдан шуурхай байдлаар [www.skytel.mn](http://www.skytel.mn) хуудаснаас авах боломжтой ба мэдээллийн ангиллаас хамааран дараах дарааллаар хандана уу.



# ДАРАА ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮССЭН МАЯГТ

Хэрэглэгчийн овог, нэр: ..... Хэрэглэгчийн утасны дугаар: ..... Хэрэглэгчийн гарын үсэг:.....

Үйлчилгээний салбар: ..... Зөвлөх ажилтан: ..... Огноо:.....

## ҮЙЛЧИЛГЭЭ ХООРОНД ШИЛЖИХ

Одоогийн багц:  10,000₮  20,000₮  40,000₮  70,000₮  100,000₮  Бусад ....

Шилжих багц:  10,000₮  20,000₮  40,000₮  70,000₮  100,000₮  Урьдчилсан төлбөрт үйлчилгээнд буцаж шилжих\*

\*Зөвхөн урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс дараа төлбөрт үйлчилгээнд шилжсэн хэрэглэгчид хамаарна.

## ГАР УТАС ДАХЬ САЛБАР ҮЙЛЧИЛГЭЭ ИДЭВХЖҮҮЛЭХ

Нүүц үг шинээр авах:  Сонгосон нүүц үг:

Нүүц үг солих:  Шинэ нүүц үг:

## ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ ИДЭВХЖҮҮЛЭХ БОЛОН ЦУЦЛАХ

Идэвхжүүлэх

Цуцлах

Үндсэн барьцаа нэмэх	Идэвхжүүлэх		Цуцлах	
	Одоогийн барьцаа	Нэмж төлөх барьцаа	Одоогийн барьцаа	Буцаах барьцаа
Олон улсын ярианы эрх	Одоогийн барьцаа	Нэмж төлөх барьцаа	Одоогийн барьцаа	Буцаах барьцаа
Олон улсын цогц роуминг үйлчилгээний эрх	Одоогийн барьцаа	Нэмж төлөх барьцаа	Одоогийн барьцаа	Буцаах барьцаа
Олон улсын роуминг үйлчилгээний хэрэглээний хязгаарлалт	<input type="checkbox"/> 100'000₮ <input type="checkbox"/> 500'000₮	<input type="checkbox"/> 300'000₮ <input type="checkbox"/> Хязгааргүй	<input type="checkbox"/> 100'000₮ <input type="checkbox"/> 500'000₮	<input type="checkbox"/> 300'000₮ <input type="checkbox"/> Хязгааргүй
Дугаар солих	Хуучин дугаар:		Шинэ дугаар:	
Үйлчилгээний эрхийг түр хаах	Эхлэх хугацаа:		Дуусах хугацаа:	
Дугаар төлбөртэй хадгалуулах	Эхлэх хугацаа:		Дуусах хугацаа:	
	Дугаар хадгалуулах төлбөр: _____ ₮			
Бусад				

## НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Скаймелоди  Нөхцөлт дугаар нууцлах  Дугаар нууцлах

Санамж: Нэмэлт үйлчилгээ нь автоматаар цуцлагдахгүй зөвхөн хэрэглэгчийн хүсэлтийн дагуу цуцлагдах тул хэрэглэгч та үйлчилгээгээ цуцлах хүсэлт гаргах хүртэл сарын суурь хураамж бодогдож байхыг анхаарна уу.